



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/1562

Номгон

Г Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх Г  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.15, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 86 дугаар тогтоолын 1.1, 1.3, 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Иргэдийн амар тайван, аюулгүй орчинд амьдрах орчныг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг нэгдсэн сүлжээнд холбох, хяналт тавих чиг үүрэг бүхий "Теле камерын хяналтын дэд төв"-ийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулсугай.

2."Теле камерын хяналтын дэд төв"-ийн серверийн болон хяналтын өрөөгөөр хангах, бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

3.Хууль, тогтоомж захирамжийн хэрэгжилтийг хангаж, Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа теле камерын стандартад нийцүүлэх, мэдээлэл холбоо, сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дэд бүтцийг ашиглан "Теле камерын хяналтын дэд төв"-д холбох иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, гудамж талбай, барилга байгууламжийн орчинд байршуулсан хяналтын камерыг "Теле камерын хяналтын дэд төв"-д холбох ажилд зааварчилгаа өгч мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбаяр)-т даалгасугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

624211429